



ТӨГСӨЛТИЙН СУРГАЛТЫН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль

1942

СУРГАЛТЫН ГЭРЭЭ № ...

1. Энэхүү гэрээг нэг талаас АШУҮИС-ийн Төгсөлтийн сургалтын бодлого зохицуулалтын газрын дарга _____ нөгөө талаас _____ ажилтай _____ зэрэг, цолтой _____ овогтой _____ (удирдагч багш - 1), _____ ажилтай _____ зэрэг, цолтой _____ овогтой _____ (удирдагч багш - 2), гуравдагч талаас _____ овогтой _____ (цаашид суралцагч гэнэ) нар харилцан тохиролцож, АШУҮИС -ийн захирлын тушаалыг үндэслэн магистр/докторын зэрэг эзэмших зорилгоор суралцах-суралцуулах үйл ажиллагааг баталгаажуулахаар байгуулав.
2. Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр болно.

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Магистрант 2 жилийн хугацаанд мэргэжлийн чиглэлээсээ хамааран 30, докторант 3 жилд 60 багц цагийг тус тус биелүүлнэ.
- 1.2. Сургалтын төлбөрийн хэмжээг тухайн хичээлийн жилд АШУҮИС -ийн Удирдах Зөвлөлөөс тогтооно.
- 1.3. Суралцагч элсэн орохдоо сургалтын төлбөрийн тооцоог бүрэн хийсэн байна.
- 1.4. Сургалтын төлбөрт багшийн хөдөлмөрийн хөлс, улсад төлөх зохих татвар, үйлчилгээний зардал, суралцагчид үйлчлэх нийтлэг төлбөргүй үйлчилгээ (компьютер болон бусад төрөлжсөн лаборатори, номын сан г.м), хичээл практикийн зардал орох ба эдгээрээс гадна суралцагчийн сургалтад ашиглагдах ном, сурах бичиг, судалгаанд хэрэглэгдэх урвалж гэх мэт нэмэлт зардлууд хамаарахгүй.

Хоёр. Төгсөлтийн сургалтын бодлого зохицуулалтын газрын эрх

- 2.1. Удирдагч багш нар гэрээнд заагдсан үүргээ биелүүлээгүй тохиолдолд олговол зохих кредитийн үнэлгээнээс хасаж тооцох.
- 2.2. Суралцагчийн сургалтын хөтчийн дагуу зайлшгүй биелүүлэх сургалтын үйл ажиллагаа болон төлбөрт хяналт тавьж, биелүүлээгүй тохиолдолд зохих журмын дагуу хамгаалалтад орох хугацааг хойшлуулах, хориг тавих, сургалтаас бүрмөсөн чөлөөлөх.
- 2.3. Суралцагч суралцах хугацаандаа сургуулийн дотоод дүрэм, нийгмийн хэв журмыг зөрчих, хууль бус үйлдэл гаргасан тохиолдолд хамгаалалтад хориг тавих, сургалтаас бүрмөсөн чөлөөлөх.

Гурав. Төгсөлтийн сургалтын бодлого зохицуулалтын газрын хүлээх үүрэг

- 3.1. БШУЯ-наас гаргасан үлгэрчилсэн журмын дагуу төгсөлтийн сургалтыг зохион байгуулан арга зүйн удирдлагаар хангах
- 3.2. Сургалтад үнэлгээ хийж хэрэгцээг тодорхойлох, бодлого боловсруулах.
- 3.3. Төгсөлтийн сургалтын бодлого зохицуулалтын газар нь гэрээ байгуулсан удирдагч багш нарын сургалттай холбоотой эрх, үүрэг хариуцлагыг тодорхойлон, сургалтад холбогдолтой зааварчилгаа өгөх.

- 3.4. Сургалтын гэрээний биелэлт, чанарт хяналт тавьж, удирдагч багш, суралцагчийн санал хүсэлтийг зохих журмын дагуу тусган ажиллах.
- 3.5. Удирдагч багш нарын хөдөлмөрийн хөлсийг холбогдох журмын дагуу хугацаанд нь бодож олгох.
- 3.6. Дотоод, гадаадын сургууль, байгууллагуудтай хамтарсан сургалтуудыг зохион байгуулах.
- 3.7. Суралцагчдад сургалт, үйлчилгээний ээлтэй найрсаг орчныг бүрдүүлэн ажиллах.
- 3.8. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, багш, удирдагч нарын үүрэгт ажил, гэрээний биелэлт, чанарт хяналт тавих.
- 3.9. Тэнхимийн эрхлэгч нарт төгсөлтийн сургалтын хөтөлбөр, стандарт, төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах үүрэг өгөх, хяналт тавих

Дөрөв. Удирдагч багшийн эрх

- 4.1. Суралцагчийн сургалттай холбоотой мэдээллийг Төгсөлтийн сургалтын бодлого зохицуулалтын газраас авах, хяналт тавих замаар Төгсөлтийн сургалтын бодлого зохицуулалтын газартай хамтран ажиллах.
- 4.2. Зохих журмын дагуу цагийн хөлсөө тооцуулах.
- 4.3. Суралцагч гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй нөхцөлд удирдагч болон зөвлөх багшаас татгалзах.
- 4.4. Сургалтын талаар санал хүсэлтийг сургуульд гаргах

Тав. Удирдагч багшийн хүлээх үүрэг

- 5.1. Удирдагч багш нь доктор (Ph.D)-ын болон түүнээс дээш зэрэгтэй, тухайн чиглэлээр 5-аас доошгүй жил эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийсэн байна.
- 5.2. Удирдагч нь сүүлийн 3 жилд эрдэм шинжилгээний өгүүлэл нэгээс доошгүй бичиж мэргэжлийн хэвлэлд хэвлүүлсэн байна.
- 5.3. Төгсөлтийн сургалтын бодлого зохицуулалтын газрын дүрэм, журам болон батлагдсан сургалтын хөтөлбөр, стандарт, төлөвлөгөөний дагуу цаг хугацаанд нь судлаачдыг оюутныг удирдан чиглүүлнэ.
- 5.4. Суралцагчийг хугацаандаа эрдмийн зэрэг хамгаалуулах талаар зохих шаардлагын дагуу удирдаж ажиллана.
- 5.5. Судлаач оюутны судалгааны ажлын талаар зөвлөгөө өгөх, харилцан ярилцах, удирдан чиглүүлэх календарчилсан төлөвлөгөөг гарган Бүрэлдэхүүн Сургуулийн төгсөлтийн сургалт хариуцсан багшаар батлуулан, нэг хувийг гэрээнд хавсаргана.
- 5.6. Удирдагч нь шинжлэх ухаан технологи, инноваци, суурь шинжлэх ухааны чиглэлээр гадаад, дотоодын эрдэм шинжилгээний төсөлт ажил дээр тулгуурлан судлаач оюутны судалгааны ажлыг явуулна.

Зургаа. Суралцагчийн эрх

- 6.1. Суралцагч нь зохих мэдлэг, чадвар, дадал бүхий багш эрдэмтнээр удирдуулах, зөвлөгөө авах, хичээл заалгах, суралцах, эрдэм шинжилгээний ажил хийхдээ тусалцаа авах
- 6.2. Сургалтын явц, чанарын талаар Төгсөлтийн сургалтын бодлого зохицуулалтын газарт санал хүсэлт гаргах, хариу авах
- 6.3. Зохих журмын дагуу сургалтад шаардлагатай лаборатори, номын сан, төгсөлтийн сургалт судалгааны танхим, судалгааны арга зүйн өрөө, багаж төхөөрөмжийг ашиглах

Долоо. Суралцагчийн хүлээх үүрэг

- 7.1. Батлагдсан сургалтын хөтөлбөрийн дагуу суралцаж, судалгаа шинжилгээний ажлын удирдамжийн дагуу сургалт, эрдэм шинжилгээний ажлыг заасан хугацаанд гүйцэтгэн үнэлүүлж зохих кредитийг биелүүлэх
- 7.2. Шалгалт бүрийн дүн магистрантад С (70%), докторант бол В (80%)-иас доошгүй байна.
- 7.3. Суралцагч өөрийн эрүүл мэнд, ар гэрийн гачигдал зэрэг хүндэтгэх шалтгаанаар сургалтаа зогсоовол сургалт зогссон тэр өдрөөр тасалбар болгон тооцож, үлдсэн хугацааны төлбөрийн 50 хувийг зөвхөн төлбөр төлөгчдөд буцааж олгоно. Суралцсан хугацааны гэрчилгээг олгоно.
- 7.4. Суралцагч сурлага, сахилгаар хасагдах болон өөрийн хүсэлтийн дагуу чөлөөлөгдвөл захиалагч байгууллагаас гарсан зардлыг буцааж төлөх асуудлыг суралцагч өөрөө хариуцна. Суралцагч нь диссертаци хамгаалахдаа амжилтгүй дүн үзүүлсэн, сурлагаар болон хугацаандаа хамгаалаагүй шалтгаанаар хасагдсан бол төлбөрийг буцааж олгохгүй.
- 7.5. Суралцагч суралцах хугацаандаа урт богино хугацаагаар гадаадад явах, бусад хүндэтгэх шалтгаанаар чөлөө авах бол удирдагч багш, Төгсөлтийн сургалтын бодлого зохицуулалтын газарт мэдэгдэн шилжилт хөдөлгөөнийг албан ёсоор хийлгэнэ. Шилжилт хөдөлгөөнийг албан ёсоор хийгдээгүй тохиолдолд суралцагчийг сургуулийг орхиж явснаар тооцон, суралцах эрх хүчингүй болсонд тооцно.
- 7.6. Хамгаалалтыг дахин хийсэн тохиолдолд суралцагч хамгаалалттай холбогдох зардлыг журмын дагуу өөрөө хариуцна.

Найм. Гэрээний заалт зөрчигдсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага

- 8.1. Гэрээ байгуулагч талуудын аль нэг нь гэрээг цуцлах санал гаргавал талууд харилцан тохиролцож гэрээг цуцална.
- 8.2. Удирдагч багш нар ямар нэг шалтгааны улмаас хамтран ажиллах боломжгүй болсон тохиолдолд урьдчилан Төгсөлтийн сургалтын бодлого зохицуулалтын газарт мэдэгдсэн байна.
- 8.3. Гэрээний биелэлтийн талаар гарсан аливаа маргааныг талууд шүүхийн бус аргаар хамтран зөвшилцөж шийдвэрлэнэ.
- 8.4. Аливаа маргааныг 8.4-д заасан нөхцөлөөр хэрэгжүүлэх боломжгүй бол маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ.

Энэхүү гэрээг байгуулагчид нь гэрээний зорилгод нийцүүлэн гэрээг оны сарын.....өдрөөс оны сарын.....өдөр хүртэл жилийн хугацаатай мөрдөхөөр тохиролцов.

Энэхүү гэрээг ____ оны ____ сарын ____ ны өдөр байгуулав.

Гэрээг байгуулсан:

ТСБЗГ-ын дарга:

_____ ()

Удирдагч багш:

_____ ()

Удирдагч багш:

_____ ()

Суралцагч:

_____ ()